



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2024.08.09 № 01/819  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ  
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ  
ДАШДОНДОВЫН ОЮУНЦЭЦЭГ  
ТАНАА

### Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Дашдондовын Оюунцэцэгийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

### Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

### Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

## Дүгнэлт

Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Дашдондовын Оюунцэцэгийн ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага болон холбогдох хууль, тогтоомжид тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Дашдондовын Оюунцэцэгийн сонгуулийн мөрийн хөтөлбөр (.3. хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Бие даан нэр дэвшигч Дашдондовын Оюунцэцэгт.

Хувийг: Хөвсгөл аймгийн Сонгуулийн хороонд.

Хавсралт .3. хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР



**Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит  
сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Дашдондовын Оюунцэцэгийн  
сонгуулийн мөрийн хөтөлбөр**

**Уриа:** Үнэнд баримжаалсан, шударга үйлийг эрхэмлэнэ.

**Миний мөрийн хөтөлбөрийн зорилго нь:**

1. Хүнээ эрхэмлэн дээдэлсэн, ёс суртахуунтай, бие бялдар, оюун санааны хувьд эрүүл аж төрөхөд суралцсан иргэнтэй Их-Уул сумыг бий болгохын тулд ажиллахад оршино.
2. Эх нутагтаа эзэн болсон, чадварлаг, эрүүл Их-Уулчуудын төлөө шударга ёс, тэгш боломжийг бий болгон хүн бүрд ээлтэй орчныг бүрдүүлэхийг зорино.

**Нэг. Хүнээ дээдэлнэ:**

1.1. Хүүхэд хөгжлийн ирээдүй

- Хүүхэд харах үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэн 1-2 насны хүүхдийг яслийн үйлчилгээнд хамруулах, ээжүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.
- Хүүхдийн мөнгөн хөтөлбөрийг дэмжин ажиллана.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгааг шинэчилж халамжийн үйлчилгээг сайжруулна.
- Жил бүр “эрүүл – хүүхэд” аян зохион байгуулж ажиллана.
- Сургуулийн насны хүүхдийг сургуульд бүрэн хамруулах зорилт тавин ажиллана.
- Оюуны бэрхшээлтэй хүүхдийг албан бус сургалтад хамруулж ажиллана.

1.2. Залуус – Хөгжлийн хөтөч

- Залуусыг МСҮТ-д мэргэжилтэй ажилтныг бэлтгэх, мэргэжүүлэх ажлыг иргэд аж ахуйн нэгж, хөрөнгө оруулагч, ажил олгогчийн саналд үндэслэн зохион байгуулна.
- Амьжиргаа дэмжих зөвлөлийн мэргэжил олгох сургалтад иргэдийг өргөнөөр оролцуулна. / тогооч, үсчин, худалдагч/

1.3. Ахмад настан - Аз жаргал


Жил бүр “Эрүүл – Ахмад” аян зохион байгуулж ажиллана.

- Ахмад настнуудад эрүүл мэндийн сургалт сурталчилгааг жил бүр зохион байгуулна.
- Тэтгэвэр тэтгэмжид хамрагдаж чадахгүй байгаа ахмадуудад хууль зүйн зөвлөгөө өгч ажиллана.

1.4. Эхчүүд, эмэгтэйчүүдэд ээлтэй бодлого

- Удирдах боловсон хүчин, төрийн албанд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана.
- Сумын эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.
- 30-65 насны эмэгтэйчүүдийг умайн хүзүүний хорт хавдар илрүүлэх үзлэг, шинжилгээнд бүрэн хамруулах ажлыг зохион байгуулна.

1.5. Ажилсаг иргэн – Амьжиргаатай өрх



З. Дорж

0000000001

- Айл бүрийг хашаандаа ногоо орчин бүрдүүлэх аян өрнүүлнэ.
- Архигүй сум – төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжиж ажиллана.
- Өрхийн газар тариалан эрхлэгчдийг дэмжиж, төсөл хөтөлбөрт хамрагдахад дэмжлэг үзүүлж ажиллана.
- Нутгийн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэх ажлыг дэмжиж ажиллана.
- Хүн амд эрүүл зан үйл төлөвшүүлэх халдварт болон халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулна.
- Нийгмийн эрүүл мэндийн болон анхан шатны эрүүл мэндийн үйл ажиллагаанд сайн дурын ажилтны оролцоог нэмэгдүүлж тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.
- Иргэний нийгмийн байгууллагатай хамтран зорилтот бүлгийг оновчтой тодорхойлж нийгмийн халамжид бүрэн хамруулах ажлыг зохион байгуулна.
- Сум хөгжүүлэх сангийн зээлийн хүртээмжийг сайжруулж өрхийн аж ахуй, хоршоо, нөхөрлөлийн хөгжилд дэмжлэг үзүүлнэ.

#### **Хоёр. Эдийн засгийн эрчимтэй хөгжил – Бүтээн байгуулалт**


- Их-Уул сумын үерийн далан барих асуудлыг холбогдох хүмүүстэй хамтран хийж, хэрэгжүүлнэ.
- Сумын төвийн замыг сайжруулж засварлах ажлыг төсөл хөтөлбөрөөр хийж хэрэгжүүлнэ.
- Сумын соёлын барих ажлыг УИХ-ын гишүүдэд өргөн мэдүүлж хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлнэ.
- Сумын төвийн гэрэлтүүлгийг ОНХС-ийн хөрөнгөөр нэмэгдүүлнэ.
- Сумын төвийн камержуулалтыг төсөл хөтөлбөрөөр нэмэгдүүлнэ.
- ЗДТГ-т цахим үйлчилгээний төвийг шат дараалалтай зохион байгуулна.
- Дулааны шугам сүлжээнд холбогдох айл өрхийн тоог нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.
- Суманд жишиг халуун устай болох ажлыг хувийн хэвшилтэй хамтран зохион байгуулна.
- Байгууллагуудын үйл ажиллагааны ил тод байдлыг дэмжинэ.

#### **Гурав. Хөдөө аж ахуй – Хөдөөгийн хөгжил**

- Бэлчээрийн усан хангамж, худгийн тоог нэмэгдүүлэх ажлыг төсөл хөтөлбөрт хамруулан шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулна.
- Малын гаралтай түүхий эд борлуулалтын цэгийн үйл ажиллагааг жигдрүүлнэ.
- Хувийн мал эмнэлгийн үйл ажиллагааг дэмжин ажиллана.
- “Шинэ хоршоо” хөдөлгөөнд иргэдийг бүрэн хамруулах ажлыг зохион байгуулж хоршооллыг дэмжинэ.

#### **Дөрөв. Байгаль хамгаалал**

- “Иргэн бүр 1 мод таръя” хөдөлгөөн өрнүүлнэ.



З. Дэг

0000000002




- Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах эргүүлэн ашиглах, устгах журмыг батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллана.
- Их-Уул сумын ойн санг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх ажлыг нутгийн иргэд төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулна.
- Ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг дэмжих замаар ойн санг хамгаална.
- Ой түймэр, хөнөөлт шавж өвчнөөс урьдчилан сэргийлэх тэмцэх ажлыг иргэд төрийн бус байгууллагуудтай хамтран сайжруулна.
- Иргэдийн ойн санг хамгаалах ухамсрыг дээшлүүлэх зорилгоор сургалт сурталчилгааг төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулна.
- Сумын ойн сангийн нөхөн сэргээлтийн ажлыг чанаржуулна.
- Ногоон гудамж, айл өрх, албан байгууллагыг ногоон шалгуураар үйл ажиллагааг урамшуулах тогтолцоог идэвхжүүлнэ.
- Сумын жилд бэлтгэх модны тоо, сумаас гадагш гаргах модны хэмжээг иргэдийн оролцоотой багийн Нийтийн хурал, Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батална.
- Мод бэлтгэлийг зөвхөн тусгаарласан талбайгаас хийлгэхэд анхаарч ажиллана.

#### **Тав. Амар тайван иргэдтэй аюулгүй Их-Уул**

- Иргэдийн ажиллаж амьдрах сурч боловсрох орчныг амар тайван аюулгүй байдалд нийцүүлж, нийгмийн хэв журмыг хамгаалан, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйлсэд төрийн бус байгууллага, иргэн бүрийн оролцоог нэмэгдүүлнэ.
- Архидан согтуурах явдлын эсрэг сургалт сурталчилгааг өргөнөөр зохион байгуулж иргэд иргэний хөдөлгөөнийг дэмжин ажиллана.
- Малын хулгайтай тэмцэхэд цагдаагийн байгууллагатай нягт хамтран ажиллана.
- Их-Уул сумын араар өнгөрөх зам дээр тэмдэг тэмдэглэгээг сайжруулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.
- Сумын төвийн камержуулалтыг төсөл хөтөлбөрөөр тоог нэмэгдүүлэх сайжруулах ажлыг зохион байгуулна.
- Байгууллага бүрийн архивын хадгалалт хамгаалалт, нөхөн бүрдүүлэлтэд онцгой анхаарч мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгүүлж ажиллана.

--ooOoo--



3. Дор

0000000003